



**Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн
2017 оны үйл ажиллагааны үр дүн**

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Агуулга

Аудитын нэр	3
Аудитын код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Аудитын хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	3
Эрсдэлийн үнэлгээ	4
Аудитын арга зүй	4
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	4
Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл	4
Аудит хийх бүрэлдэхүүн	5
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	5
Хавсралтууд	6

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын нэр

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Аудитын код

ГАГ-2018-07-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө, сэдэв батлах тухай” 2018 оны А/06 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт

“Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- МҮОНРТ-ийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
- МҮОНРТ-ийн санхүү, хөрөнгө, нөөцийг зохих ёсоор бүрдүүлж, үр ашигтай удирдаж байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017 оны үйл ажиллагааг хамруулна.

Үндсэн мэдээлэл

Радио нэвтрүүлгийн үйл ажиллагаа 1934 онд, Монголын үндэсний телевиз 1967 онд байгуулагдаж, телевизийн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эхэлснээр Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэс суурь тавигдсан байна.

Улсын Их Хурлаас 2005 онд “Олон нийтийн радио телевизийн тухай хууль”-ийг баталж, Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 241 дүгээр тогтоолоор Монголын радио, Монголын үндэсний телевизийн үйл ажиллагааг нэгтгэсэн Радио телевизийн хэрэг эрхлэх газрыг татан буулгаж, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийг байгуулсан байна.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз 2017 онд бүтцийн үндсэн 5 нэгж 680 орон тоотойгоор телевизийн 2 сувгаар 7 хоногт 238 цагийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр, радиогийн 3 сувгаар 7 хоногт 266 цагийн нэвтрүүлгийг олон нийтэд хүргэж ирсэн бөгөөд

Монголын дуу хоолой радио Монгол, Орос, Хятад, Япон, Англи зэрэг 5 хэл дээр нэвтрүүлгээ цацаж байна.

Үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор 2017 онд 6.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 5.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг улсын төсвөөс авсан байна.

МҮОНРТ үндсэн үйл ажиллагааны орлогоор 2016 онд 10.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажилласан байна.

Удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн, УИХ 7 хүн, Засгийн газар 4 хүнийг тус тус нэр дэвшүүлснээр УИХ-аар батлагдсан орон тооны бус гишүүнчлэлтэй 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, үйл ажиллагаа явуулахтай холбоотой хөрөнгө санхүү, бодлогын асуудлууд, тайланг хэлэлцэн шийдвэр гарган ажиллаж байна.

Ерөнхий захирал нь Үндэсний зөвлөлтэй эдлэх эрх, үүрэг, хүлээх хариуцлага болон холбогдох бусад харилцааг зохицуулах Контракт байгуулж, өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, аргачлалуудын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “Их” гэж үнэлэв. *(Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-ээс үзнэ үү.)*

Аудитын арга зүй

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд дурдсан аудитын арга зүйг мөрдөж аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. *(Асуудлын шинжилгээг хавсралт № 2, аудитын арга зүйг хавсралт №3-аас үзнэ үү)*

Аудитын төлөвлөгөөнд аудитын явцад нэмэлт өөрчлөлт хийж болно.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль;
- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн дүрэм;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Хөдөлмөрийн дотоод журам;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол,
- бусад холбогдох дүрэм, журмууд

Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл

Аудитын урьдчилсан судалгааны ажлыг 2018 оны 3 дугаар сарын 1-нээс 3 дугаар сарын 16 хүртэл, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 3 дугаар сарын 19-нөөс 3 дугаар сарын 20

хүртэл гүйцэтгэж, төлөвлөгөөг 2018 оны 3 дугаар сарын 27-ны дотор батлуулж, талбарын ажлыг 2018 оны 3 дугаар сарын 28-наас 4 дүгээр сарын 16 хүртэл, тайлагналын үе шатны ажлыг 2018 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 8 хүртэл гүйцэтгэж, тайланг 2018 оны 5 дугаар сарын 10-нд УИХ-д хүргүүлнэ. (Аудитын хөтөлбөрийг хавсралт № 4-өөс үзнэ үү.)


Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна холбогдох байгууллагын саналыг тусгана.


Аудит хийх бүрэлдэхүүн

Аудитыг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа үе шатны хяналтыг хэрэгжүүлж, хөтөлбөрийн дагуу ахлах аудитор Б.Долгорсүрэн, аудитор Д.Баатархуяг, М.Гүнжмаа, нар гүйцэтгэж, шаардлагатай мэдээлэл, тодруулга гарган нэгдсэн тайлан бичнэ.

Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

- а. Боловсон хүчин: УАГ: 5 хүн*54 өдөр =270 хүн/өдөр
б. Санхүүгийн нөөц: Цалин 12.3 сая төгрөг
Бичиг хэрэг 35.0 мянган төгрөг
Нийт 12.3 сая төгрөг
в.Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг хянаж, зөвшөөрсөн:
Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор  С.Оюунбилэг

Боловсруулсан:
Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор  М.Давааням

Аудитын менежер  З.Ариунзаяа

Ахлах аудитор  Б.Долгорсүрэн

Аудитор  Д.Баатархуяг

 М.Гүнжмаа

2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр